

“ТАЛЫН ГАЛ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 02 дугаар сарын 18-ны өдөр

№01

Улаанбаатар хот

“Талын гал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар тус компанийн 2020 оны жилийн санхүүгийн тайлан, хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах эсэх тухай авч хэлэлцээд ТОГТООХ нь:

1. “Талын гал” ХК-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийг авч хэлэлцээд тус компанийн хувьцаа эзэмшигчдэд нэг хувьцаанд 50,0 /тавин/ төгрөгийн ногдол ашиг хуваарилах нь зүйтэй гэж үзсүгэй.
2. Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны “Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай” 28 дугаар тогтоолын дагуу тус компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид болох Т.Санжаа, У.Батсуурь, С.Янжмаа нараас бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн эдгээр хүмүүсийн ногдол ашгийг тэдгээрийн эзэмшигч дансанд, бусад хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг эрх бүхий зуучлагч байгууллага болох “ҮЦТХТ” ХХК-тай гэрээ байгуулан энэ оны 6 дугаар сарын 1-ний дотор тарааж олгохыг Гүйцэтгэх захирал С.Цэрэндондовт даалгасугай.
3. Компанийн тухай хуулийн дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бэлтгэл ажлыг зохих журам дүрмийн дагуу бүрэн хангаж ажиллах, компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, тус хурлаар хэлэлцүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга У.Батсуурь, Хянан шалгагч Ш.Мягмарсүрэн, Гүйцэтгэх захирал С.Цэрэндондов нарт даалгасугай.

“ТАЛЫН ГАЛ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



У.БАТСУУРЬ